

Аймгийн хэмжээнд бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах тогтвортой менежментийг толовшүүлэх вйлсэд сумдын бэлчээр ашиглагчдын холбоод, Бэлчээр Ашиглагчдын Хэсгүүд болон бусад оролцогч дэмжигч талуудын вйл ажиллагааг уялдуулж нэгтгэн зохион байгуулах замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх, ходоогийн хогжлийг хангахад зохих хувь нэмэр оруулах зорилгоор Аймгийн Бэлчээр Ашиглагчдын Холбоод 13 аймагт байгуулагдаад байна.

Аймгийн Бэлчээр Ашиглагчдын Холбоод нь бэлчээрийн менежментийн талаар аймгийн бодлого, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн **санал, зөвлөмж** боловсруулах ажлыг оролцогч талуудын оролцоонд тулгуурлан зохион байгуулж аймгийн холбогдох дээд байгууллагад тухай бүр уламжилж тэдэнтэй хамтран ажиллах, бэлчээрийг зохистой эзэмших, ашиглах, хамгаалахад чиглэгдсэн малчдын хамтын вйл ажиллагааг дэмжиж СБАХ-дод **арга зүй, менежментийн зөвлөгөө** огох вйлчилгээ үзүүлэх, СБАХ, нохорлол, холбоодын үүсгэл санаачлагыг дэмжиж, бэлчээрийн хамтын менежментийн толовлогоо боловсруулах хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулах, бэлчээрийн менежмент, экологийн боловсрол олгох малчдын орлого нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр тэдэнд зориулсан сургалтын хотолбор **боловсруулж сургалт явуулах**

**хялбарчилсан мэдээ мэдээлэл, материал**

бэлтгэж

**дэлгэрүүлэн түгээх**

ажлыг сумдын бэлчээр ашиглагчдын холбоо, нохорлол болон бусад байгууллагын зохион байгуулалтын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, бэлчээрийн нэгж талбар дахь малчин орх, малчдын холбоо, хэсэг бүлэг нохорлолийн орлогыг нэмэгдүүлэхэд

**гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн дэмжлэг туслалцааг чиглүүлэхэд**

анхааран ажиллах, Бэлчээрийн менежментийн оноогийн чиг хандлага, бэлчээрийн толов байдлын талаарх

**судалгаа шинжилгээний**

ажлын үр дүнг нийтэд

**хүртээмжтэй болгох**

бэлчээр сайжруулах шинэ технологийг сурталчлан таниулах, аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдтэй хамтран ажиллах зэрэг вйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж эхлээд байна.